



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай ” 2023 оны 05/12576 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн “Архангай АЗЗА” ТӨХК, “Өвөрхангай АЗЗА” ТӨХК, “Хархорин АЗЗА” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Б.Амарбаясгаланг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс томилсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ